



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/54

Хөхөө

Үнэлгээ хийх баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Монгол улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой байдлын газрын мэргэжилтнүүдтэй хамтран 2024 оны зуны улиралд үер усны болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах зорилгоор эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх Үнэлгээний багийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: З.Анхсанчир – Сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Б.Баярцэцэг – Хууль эрх зүйн мэргэжилтэн

Г.Чулуунбаатар – Газрын даамал

Т.Алтанчимэг – Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Б.Мөнхгэрэл – Байгаль хамгаалагч

Д.Мөнгөнцэцэг – Цаг уурын харуул

Б.Энхтунгалаг – Насан туршийн боловсролын багш

2. Үерийн усны ерөнхий үнэлгээг хийх ажлыг удирдан зохион байгуулж ажиллахыг үнэлгээний баг (З.Анхсанчир)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Баасанжав)-д даалгасугай.

ДАРГА

Л.ЭНХЖАРГАЛ

